БАТЛАВ. ХАВДАР СУДЛАЛЫН ҮНДЭСНИЙ ТӨВИЙН ЕРӨНХИЙ ЗАХИРЛЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

..........................

Н.ЭРДЭНЭХҮҮ

БАТЛАВ. "ТДЕ" ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..........................

Д.ГАНБОЛД

ХАРУУЛ ХАМГААЛАЛТЫН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭХ ГЭРЭЭ

Дугаар: ХХҮҮГ-2021/01

Улаанбаатар хот

Нэг талаас **Хавдар судлалын үндэсний төв** (цаашид "захиалагч" гэх), нөгөө талаас **"ТДЕ" ХХК** (цаашид "нийлүүлэгч" гэх) нар дараах зүйлийг харилцан тохиролцож **2021** оны **01** дугаар сарын **02**-ний өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид "гэрээ" гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу үйлчилгээ үзүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь **Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ**-г (цаашид "үйлчилгээ" гэх) **18.300.000 /арван найман сая гурван зуун төгрөг/** (цаашид "гэрээний үнэ" гэх) төгрөгөөр нийлүүлэхээр нийлүүлэгчийн ирүүлсэн үнийн саналыг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Захиалагч нь ажлын хөлс **18.300.000 /арван найман сая гурван зуун төгрөг/** төгрөгийг төсвийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.

4. Нийлүүлэгч нь **Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ-г 2021** оны **01** дүгээр сарын **02**-ний өдрөөс **2021** оны **03** дугаар сарын **31**-ны өдрийн дотор захиалагчид гүйцэтгэж дуусгана.

5. Захиалагч нь **Гэрээт харуул хамгаалалтын үйлчилгээ** -г гүйцэтгэж дууссаны дараа гүйцэтгэлийг дүгнэж төлбөрийг гүйцэтгэнэ.

6. Дор дурдсан баримт бичиг нь цаашид гэрээний хэсэг болно (цаашид "гэрээний баримт бичиг" гэх). Үүнд:

   Гэрээний тусгай нөхцөл;
   Гэрээний ерөнхий нөхцөл;
   Үйлчилгээний тодорхойлолт болон үйлчилгээний хуваарь;
   Санхүүжилтийн хуваарь.

7. Үйлчилгээ үзүүлэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

8. Үйлчилгээ үзүүлэгч нь энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан үйлчилгээг гүйцэтгэж, гэрээний явцад гарсан зөрчил, дутагдлыг арилгах үүрэг хариуцлагыг хүлээж байна.